



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд  
Монгол Ардын намаас нэр дэвшигч Ш.Мөнгөнтуяаг  
бүртгэх тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.5, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.10, 32 дугаар зүйлийн 32.2, 32.3, дүүргийн Сонгуулийн хорооны 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн дүүргийн Сонгуулийн хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Ардын намаас Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 7 дугаар тойрогт нэр дэвшүүлсэн Шаравнямбуугийн Мөнгөнтуяа /ИО86041608/-г нэр дэвшигчээр бүртгэсүгэй.

2. Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Нарийн бичгийн дарга Д.Дэлгэрмаад даалгасугай.

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигч Ш.Мөнгөнтуяад нэр дэвшигчийн үнэмлэх олгосугай.

ДАРГА

Я.ЭРДЭНЭСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Д.ДЭЛГЭРМАА



0000000056